# 소망의 여인들

## Prayer Calander

2024년 12월

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



### Баруун болон Төв Африкийн эмэгтэйчүүдэд зориулсан залбирал 2

Арван хоёрдугаар сар аль хэдийнээ болж, итгэмээргүйгээр хурдан жилийн төгсгөл иржээ. Их Эзэн дэлхийн өнцөг булан бүрт байгаа эмэгтэйчүүдэд итгэл найдварыг өгөхийн тулд манай TWR-ийн Найдвар доторх эмэгтэйчүүдийн багуудын үйлчлэлээр дамжуулан онцгойлон ажиллаасаар байна. Найдвар доторх эмэгтэйчүүд нэвтрүүлгийг сонсдог олон хүмүүс Есүсийг Аврагчаа хэмээн хүлээн зөвшөөрч, одоо болон үүрд мөнхөд үнэн найдвараар Түүнд амьдралаа өгсөн. Түүний бидэнд өгсөн Есүсийн бэлгээр дамжуулан та болон таны хайртай хүмүүс Их Эзэн Есүсийн мэндэлсэн баярыг утга учиртай, гайхалтайгаар өнгөрүүлэх болтугай.

카카오톡 채널에서 ‘소망의 여인들’ 채널을 추가하시면
매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Аав аа, Та бидэнд “Өөрийнхөө өмнөөс ярьж чаддаггүй хүмүүсийн төлөө ярь” тушаасанчлан эмэгтэйчүүдийг мөлжлөгөөс ангижруулахын төлөө ажиллаж буй хүмүүсийг Та зоригжуулаач. (Сургаалт үгс 31:8)

2. Бурхан минь, Сенегалын ард түмэн гаж урсгалын удирдагчдыг ялгаж салгаж, сүм чуулганыг сонгохдоо ухаалаг байж, хуурамч шүтээнүүдээс ангижрах болтугай. (Кол. 2:8)

3. Эзэн минь, Нигерийн зүүн хэсэгт амьдарч буй хүмүүст амар амгалан, хамгаалалт, аюулгүй байдлыг өгөөч. Та тэднийг үл мэдэгдэх зэвсэгт этгээдүүдийн халдагаас хамгаалах болтугай. (Дуу. 91:1–5)

4. Аав аа, Мали улсын залуучууд өөрсдийн эзэмшсэн мэргэжлээрээ ажил хийх бүх боломжоор хангагдах болтугай. Та тэдэнд итгэл найдах итгэлийг Та өгөх болтугай. (Ром. 12:12)

5. Бурхан минь, Либери улсад шинээр сонгогдсон удирдагчдад эр зориг, мэргэн ухааныг өгөөч. Христэд итгэгчид эрүүл мэнд, ажил, боловсролын талаар шийдвэр гаргахдаа Таныг сонсож, Таны үгэнд дуулгаьартай байх болтугай. (Дуу. 72)

6. Аав аа, Габоны ард түмнийг өвчлөлөөс хамгаалагдахын төлөө бид залбирч байна. Тэднийг эрүүл мэндийн сайн үйлчилгээ авах бүх боломжоор хангах болтугай. (Дуу. 103:2–3)

7. Эзэн минь, эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зан үйлийг таслан зогсоохын тулд нөлөөлж чадах Кот-д'Ивуарын хойд хэсгийн удирдагчдын зүрх сэтгэлд Та ажиллаач. (Сур. 31:8–9)

8. Ариун Сүнс ээ, Төв Африкийн Бүгд Найрамдах Улсдахь эмэгтэйчүүдэд сэргэлтийг авчрах болтугай. Тэдний г Христ дотор итгэлээр өсөхөд нь туслахын тулд манай TWR Women of Hope багийг ашиглах болтугай. (Еф. 3:16–19)

9. Хүчээр гэрлэлтийн золиос болсон Бенин дэх эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх болтугай хэмээн Эзэн минь бид залбирч байна. Тэд таныг таньж, Танаас ирэх амар тайвныг авах болтугай. (Ис. 41:10)

10. Аав аа, Нигерийн хойд хэсэгт итэгээлээрээ хавчигдаж буй буй Христэд итгэгчдийг Та хүчирхэгжүүлж, хамгаалаалах болтугай. (2 Тим. 3:11)

11. Бурхан минь, гэр бүл салахаар шийдэж Малигийн Христэд итгэгчдийн гэрлэлтийг Та хамгаалаач. Эдгээр хосуудад асуудлаа зөвөөр шийдвэрлэх мэргэн ухааныг Та тэдэнд өгөх болтугай. (Мат. 19:6)

12. Аав аа, Либери дэх ядуу зүдүү залуучуудын амьдралд байгаа буруу зуршлуудын цайзыг эвдсэн Таны сайн мэдээний хүч чадалд талархаж байна. (Ром. 1:16)

13. Бурхан минь, Габоны удирдагчид шударга байж, ил тод байж, үндэстэн, ард түмнийхээ сайн сайхны төлөө шударгаар хамтран ажиллахын төлөө бид залбирч байна. (1 Тим. 2:1–2)

**TWR Korea 북방선교방송**
서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층
전화 (02)886-5671 / 이메일 hskim@twrk.or.kr

14. Эзэн минь, Есүсийн нэрээр Кот-д'Ивуар дахь амиа хорлохоор шийдсэн хүмүүс чөлөөлөгдөж, Таны дотор жинхэнэ амийг олох болтугай. (Иов 33:4)

15. Аав аа, Төв Африкийн Бүгд Найрамдах улсад хүчирхийлэлд өртсөн ядуу, ганц бие эмэгтэйчүүдийг Та хамгаалаач. Тэд үр хүүхдээ тэжээхэд хэрэгтэй бүхнээр Та хангах болтугай. (Дуу. 82:3)

16. Бид Бенин улсад тохиолдсон эдийн засгийн хямралаас болж, санхүүгийн хүнд байдалд орсон эмэгтэйчүүдэд ажлын байр, санхүүгийн эх үүсвэрээр Та хангах болтугай. (Дуу. 81:16)

17. Аав аа, Нигерийн ард түмнийг шашны зан үйл болон нутгийн шашинлаг зан үйлд хэт хэт автахаас Та хамгаалах болтугай. Тэд Тантай амьд харилцаатай байж, Танаас зуурах болтугай. (Иохан 4:24)

18.Бурхан минь, Мали дахь терроризмын улмаас эхнэр, нөхөр, эцэг эхээ алдсан хүмүүсийг Та тайтгаруулаач. Гэмт этгээдүүд хуулийн өмнө ирж, хариуцлагаа хүлээх болтугай. (Ис. 1:17)

19. Аав аа, хар тамхины донтолт, бэлгийн хүчирхийлэлд өртсөн Либери дэх охидыг Та эдгээгээч. Эцэг эх нь тэднийг хүндэлж, хайрлаж, халамжлах болтугай. (Еф. 6:4)

20. Бурхан минь, Кот-д'Ивуар дахь Найдвар доторх эмэгтэйчүүдийг сонсдог эмэгтэйчүүд сонссон зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд тэдний амьдрал өөрчлөгдөх болтугай. (Ром. 12:2)

21. Аав аа, Төв Африкийн Бүгд Найрамдах Улсын хууль тогтоогчдод гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг хамгаалах хууль батлахад тэдний зүрх сэтгэлийг хөдөлгөх болтугай. (Дуу. 10:17–18)

22. Аав аа, Бенин улсад, бие махбодь, сэтгэлзүйн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд болон өнчин хүүхдүүдийг аварч, Та тэднийг эдгээх болтугай. (Дуу. 72:4)

23. Эзэн минь, Габон дахь Христэд итгэгчид улс орныхоо энх тайван, шударга ёсны төлөө чин сэтгэлээсээ залбирахад нь туслаарай. Тэнд байгаа итгэгчид эргэн тойрныхоо хүмүүст Таны хайр, нигүүлслийг дамжуулах болтугай. (Мик. 6:8)

24. Бурхан минь, Нигери улсад инфляци өндөр байгаагаас болж зовлон зүдгүүр, ядууралд нэрвэгдээд байгаа гэр бүлүүдэд ивээлээ асгах болтугай. (Дуу. 23:1)

25. Эзэн минь, Мали, Нигер, Буркина Фасо улсуудыг хамарсан Сахел улсуудын холбоонд нийгэм, улс төр, аюулгүй байдал тогтворжихын төлөө бид залбирч байна. (Ром. 12:18)

26. Аав аа, Либери улсад гудамжинд амьдарч буй залуучуудад сүнслэг байдал болоод бие хэрэгцээг нь хангахын тулд тэдэнд тусалдаг Христэд итгэгч эмэгтэйчүүдэд мэргэн ухаан, хүч чадал өгөөч. (Иаков 2:26)

27. Бурхан минь, Габоны залуучуудыг чанартай боловсролыг эзэмшихэд нь тэдэнд мэргэн ухаанаар зөвлөгөө агдаг хүмүүсийг тэдэнд илгээх болтугай. (Сур. 11:14)

28. Эзэн минь, Кот-д'Ивуар дахь ёс суртахуунгүй байдлыг өөгшүүлсэн контент бүтээдэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг Та өөрчлөөч. Тэд зөв шударга, цэвэр амьдралд урилсан контентуудыг бүтээх болтугай. (Флп. 2:15–16)

29. Бурхан минь, Либери дэх "Найдвар доторх эмэгтэйчүүд" нэвтрүүлэгийг сонсохын тулд нарны эрчим хүчээр ажилладаг радиог тараах санхүүжилтээр Та хангах болтугай. (Мат. 7:7–8)

30. Габоны цэргүүдийн эхнэр, хүүхдүүд бусдад үл тоомсорлогдож, хүнд хэцүү нөхцөлд амьдарч байна. Аав аа, манай багт эдгээр нандин сүнснүүдэд үйлчлэх боломжийг нээж өгөөч. (Дуу. 9:9–10)

31. Эзэн минь, бид Кот-д'Ивуарын эмэгтэйчүүд Тан руу хандан залбирч, Тантай дотно харилцаатай байхад нь Ариун Сүнс ээ Та удирдах болтугай. (Мат. 6:6)

**Монголын төлөө залбирах сэдвүүд ----------------------**

1. Бурхан минь Монгол улсын боловсролын системд шинэчлэл хийгдэж, хүүхдүүд үнэнийг зааж, үнэн рүү хөтлөх болтугай. Христэд итгэгч багш нар шударга байдал болон энэрэнгүй байдлаа, итгэлээсээ ичихгүйгээр ажиллах болтугай.
2. Бурхан минь Монгол улсад өдөр өсөж байгаа өргөн хэрэглээний бараа, тог цахилгаан болон бусад хүний нэн тэргүүний хэрэгцээтэй зүйлсийн үнэ тогтвортой байхад Аав аа Та бүгдийг хяналтандаа авах болтугай.
3. Аав аа, бяцхан хүүхдүүдийг ханиад томууны дэгдэлтээс Та хамгаалаач.